



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Г Холболтын журам шинэчлэн батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13, 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн, Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн саналыг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дулаан дамжуулах, түгээх сүлжээний “Холболтын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа мөрдөж ажиллахыг дулаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд /дарга, захирал/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад зөвлөмж өгч ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газар /хуучин нэрээр/-ын “Холболтын заавар батлах тухай” 2002 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 91, “Холболтын заавар батлах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2003 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 12, “Холболтын заавар батлах тухай” 2009 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны “Журам батлах тухай” 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 08, “Журам батлах тухай” 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 226, “Журам батлах тухай” 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 100, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 316 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн
290 дүгээр тогтоолын хавсралт

УХААНЫ НӨХЦӨЛ

ДУЛААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ “ХОЛБОЛТЫН ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дулаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх)-ийн сүлжээнд иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламж, тоног төхөөрөмж(цаашид объект гэх)-ийг холбоход энэхүү журмыг мөрднө.

1.2 Энэхүү журмын зорилго нь дулаан дамжуулах, түгээх сүлжээнд объектоо холбуулах иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, объект, тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх, сүлжээнд холбох үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхойлоход оршино.

1.3 Иргэн, хуулийн этгээдийн дэд станц, шугам, тоног төхөөрөмж, объектыг дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох шийдвэр нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техникийн нөхцөл байна.

1.4 Техникийн нөхцөл хүсэж буй иргэн хуулийн этгээдийн объект нь дулаан түгээх сүлжээнээс холбогдох бол дулаан түгээх сүлжээний өмчлөгч буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дулаан дамжуулах сүлжээний өмчлөгч буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тодруулга авсны үндсэн дээр техникийн нөхцөл олгоно.

Хоёр. Сүлжээнд холбогдох хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх

2.1 Шинээр баригдах, өргөтгөл шинэчлэл хийх барилга байгууламжид дулааны эрчим хүч авах, ачааллыг нэмэгдүүлэх болон дулааны, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх шаардлага гарсан тухай бүрт хэрэглэгч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс дулааны техникийн нөхцөл авна.

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шинээр хэрэглэгч нэмж холбох боломж, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд хийгдэхээр хөрөнгийн эх үүсвэр нь батлагдсан өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын талаарх мэдээллийг газар зүйн байршилаар нь гаргаж улирал бүр нийтэд мэдээлнэ.

2.3 Дулаан дамжуулах, түгээх сүлжээнд объектоо холбуулах хүсэлтээ иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл олгогчийн цахим хуудсаар эсвэл өөрийн биеэр дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө. Үүнд:

2.3.1 Албан бичиг, өргөдөл;

2.3.2 Иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.3.3 Техникийн нөхцөл олгогчоос өгсөн тодруулах хуудасны бүрдэл; /Нэгдүгээр хавсралт/

2.3.4 Газрын гэрчилгээ (өмчлөх, ашиглах, эзэмших), (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.3.5 Газрын кадастрын зураг (эх хувь, эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.3.6 Дулааны ачаалал, хэрэглээг тооцсон тоо хэмжээ;

2.4. Иргэн, хуулийн этгээд нь энэхүү журмын 2.4-т заасан баримт бичгээс гадна хүсэлтийн онцлогоос хамаарч дараах материалуудыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

2.4.1 Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан барилга орон сууц барих тохиолдолд Архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан “Ерөнхий төлөвлөгөө” (эх хувь эсвэл хуулбарыг гэрчлүүлсэн байх);

2.4.2 Олгогдсон техникийн нөхцөлд өөрчлөлт оруулахад өмнөх техникийн нөхцөлийн хуулбар хувь;

2.4.3 Техникийн нөхцөлийн нэр шилжүүлэхэд өмнө олгогдсон техникийн нөхцөлийн эх хувь, газрын гэрчилгээ, харьяа хорооны тодорхойлолт;

2.4.4 Дулаан түгээх сүлжээг зөөж байршлыг өөрчлөхөд түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зураг төсөлд тодруулга тодорхойлолт, харьяа орон нутгийн ерөнхий төлөвлөгөө эрхэлсэн газрын албан хүсэлт;

2.4.5 Хэрэв бусдын өмчлөлийн дулааны шугам, тоног төхөөрөмжид барилга, объектыг холбох бол тухайн өмчлөгчтэй зөвшилцсөн /гэрээ, тодорхойлолт, албан бичиг/ бичиг;

2.5 Техникийн нөхцөл олгогч нь иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хүсэлт гаргагчийн хамт дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдох техникийн боломж, хамгаалалтын зурvas зөрчсөн эсэхийг газар дээр нь тодорхойлж, хүчин чадал, сүлжээний гидравлик тооцоо, шаардлагатай өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг төлөвлөн, холбогдох зардлын тооцоог хийж судалж шийдвэрлэнэ.

2.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн нөхцөл олгохдоо дамжуулах, түгээх сүлжээний ачаалал, тухайн бус нутгийн өсөн нэмэгдэх дулааны хэрэглээ, хэтийн төлөвтэй уялдуулан шийдвэрлэнэ. Дулааны ачааллын үнэн зөв, эсэхийг тодруулах хуудас бөглөсөн иргэн, хуулийн этгээд хариуцна.

2.7 Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацааг объектын дулааны ачаалал, барилга, угсралтын гүйцэтгэх хугацаа зэргээс хамааруулан 1-3 жилээр тогтооно.

2.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдэд шинээр техникийн нөхцөл олгохдоо халаалт, хэрэгцээний халуун усны системд дулааны тоолуур суурилуулах, дулааны тоолуур суурилуулах техникийн боломжгүй барилга, байгууламжийн хэрэгцээний халуун усны системд усны тоолуур зайлшгүй суурилуулах талаар тусгаж зураг, төслийн хэрэгжилтэд хяналт тавьна.

2.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дулаан түгээх, хангах үйл ажиллагааг дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэхээр тусгасан байна.

2.10 Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөлд заасан хугацаанд тухайн объектоо түгээх сүлжээнд холбох боломжгүй бол техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтийг гаргах бөгөөд техникийн нөхцөлийг нэг удаа сунгана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.

2.11 Иргэн, хуулийн этгээдийн шинээр барих, зөөх дэд станц, шугамын трасс нь тухайн хот, суурин газрын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, дэд

бүтэц төлөвлөлтийн дагуу дулааны байгууламж баригдахаар төлөвлөгдсөн, төлөвлөгдөөгүй боловч тухайн орчинд нийтийн сүлжээ үүсэх боломжийг хаасан, сүлжээ төлөвлөлт, горимын хувьд ач холбогдол бүхий дулаан дамжуулах гол шугам үүсгэхээр байвал тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн хуулийн этгээдийн барих шугам тоноглолыг харилцан тохиролцож өмч шилжүүлэх тухай гэрээ байгуулан техникийн нөхцөл олгоно.

2.12 Иргэн, хуулийн этгээдийн объектын холболтын цэг нь зайлшгүй хувийн эзэмшлийн шугамаар дамжуулан холбогдох бол тухайн шугам тоноглол эзэмшигчээс зөвшөөрөл авч баталгаажуулсан байна. Хувийн шугамаас дамжин холбогдсон хэрэглэгчийн шугамд нэмж хэрэглэгч холбох нөхцөл үүссэн тохиолдолд хангагчаас уг шугамд нэмж болох, эсэх талаар тодруулга авч, дамжин холбогдсон хэрэглэгч нь эхний шугамын эзэмшигчтэй зөвшилцөн гэрээ байгуулсны дараа хэрэглэгчийг холбох зөвшөөрлийг олгоно.

2.13 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл авах хүсэлтийг шийдвэрлэсэн хугацаа, үндэслэл зэргийг өөрийн цахим хуудсанд сар бүр нийтэлнэ.

2.14 Тусгай зөвшөөрөл эзэмшигч техникийн нөхцөл олголтын талаарх мэдээг тогтоосон маягтын дагуу улирал тутам Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлнэ.

2.15 Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.

2.16 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олгосон техникийн нөхцөлийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн, нэмэгдэх болон хүлээгдэж буй ачааллын судалгааг гаргаж сүлжээ төлөвлөлтөд ашиглана.

Гурав. Техникийн нөхцөлийн агуулга

3.1 Техникийн нөхцөлд дараах асуудлуудыг тусгасан байна.

3.1.1 Дулааны тооцоот ачаалал;

3.1.2 Холболт хийх цэг (Дулааны станц, халаалтын зуух, дулаан дамжуулах төв, дулаан түгээх шугам), дулаан зөөгчийн температур даралт;

3.1.3 Объектыг шинээр холбосноос болон хэрэглэгч дулааны ачааллыг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан өргөтгөл хийх, эсэх;

3.1.4 Тоолуур хэмжих хэрэгсэл;

3.1.5 Объектод тавигдах тусгай шаардлага;

3.1.6 Холболтын схем;

3.1.7 Объектын ашиглалт аюулгүй ажиллагааг хангах шаардлага;

3.1.8 Иргэн, хуулийн этгээд нь барилга барих явцад дулаан авах бол түр холболт хийх цэг, хугацааг тодотгосон байх;

3.1.9 Орчны тохижилтийг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ;

3.1.10 Техникийн нөхцөлийн хугацаа;

3.2.11 олбогдох шийдвэрийн заалт;

3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу зориулалт, дулааны ачаалал, холболтын цэгийг өөрчлөх, тухайн холбогдож буй сүлжээний онцлогоос хамааруулан техникийн нөхцөлийн тусгай заалтууд хэсэгт нэмэлт шаардлагуудыг оруулж болно.

3.3 Барилга, объект нь дулаан дамжуулах сүлжээнээс холбогдох бол шугам сүлжээг барьж байгуулсны дараа дамжуулагчийн өмчид шилжүүлэхээр техникийн нөхцөлд тусгана.

Дөрөв. Объектыг дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбох

4.1 Техникийн нөхцөлд тусгасан шаардлагыг хангасан объектыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох мэргэжилтний хяналтан дор дулаан түгээх сүлжээнд холбоно. Тус объектын дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хянуулж батлуулсан зураг, төслийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.

4.2 Иргэн, хуулийн этгээд нь дулаан түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, дулаан дамжуулах төвийг анх ашиглалтад оруулахдаа гүйцэтгэлийн баримт бичиг, туршилтын акт, протоколыг бүрдүүлэн архив, мэдээллийн санд бүртгүүлэн байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулж дүгнэлт гаргуулсан байна.

4.3 Дулааны сүлжээнд объектоо холбуулах иргэн, хуулийн этгээд нь дор дурдсан баримт, материалыг бүрдүүлэн объектыг холбуулахад бэлэн болсон тухайгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан ёсоор мэдэгдэнэ. Үүнд:

4.3.1 Объектын дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэлийн зураг, схем, далд ажлын болон угаалга, шахалтын актууд;

4.3.2 Шинээр суурилуулсан дулааны тоолуурын угсралтын акт түүний баримт бичиг, тоолуур суурилуулсан аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хуулбар;

4.4 Дулааны шугам сүлжээнд энэхүү журмын 5.2, 5.3-д заасан материал нь бүрдсэн объектыг холбох ажлыг төв шугамд жил бүрийн 5-р сарын 15-наас 9-р сарын 15, салбар шугамд жил бүрийн 03-р сарын 01-ээс 11-р сарын 01-ний дотор хийнэ.

4.5 Дээрх хугацаанаас бусад үед /гадна агаарын температур -15°C-аас илүү хүйтэрсэн/ шинээр шугам, тоноглол, барилга объектыг дулаанд холбох шаардлага гарвал техникийн нөхцөл олгох комиссын дүгнэлтийг үндэслэн зохих бэлтгэлийг хангуулж тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

4.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь объектыг дулаан түгээх сүлжээнд холбоодоо иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хийж гүйцэтгэн дулааны шугам, тоног төхөөрөмжийг хянаж батлуулсан зургийн дагуу бүрэн угсарсан, эсэхийг шалгаж, тоолуур хэмжих хэрэгслийг лацдаж битүүмжилнэ.

4.7 Шинээр холбогдсон хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.13 дахь заалтад хамрагдахгүй бол холбогдсон шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагийн дагуу техникийн нөхцөл олгогч, бусад түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй дулаан худалдах, худалдан авах гэрээ байгуулна.

4.8 Шинээр холбогдсон хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.13 дахь заалтад хамрагдсан тохиолдолд тухайн объектын дулаан дамжуулах төв, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэн хангагчтай дулаан худалдах, худалдан авах гэрээ байгуулна.

Тав. Санхүүгийн нөхцөл

5.1 Иргэн, хуулийн этгээдийн объектыг дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбоод хүсэлт судлах, техникийн нөхцөл олгох, техникийн нөхцөлийн дагуу холбох үйлчилгээ үзүүлэх төлбөрийг иргэн, хуулийн этгээдээс авна.

5.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өсөн нэмэгдэх дулааны хэрэглээг хангах зорилгоор өөрийн эзэмшлийн дулаан дамжуулах төв, дулааны шугам, тоноглолтыг өргөтгөх үүрэгтэй.

5.3 Тухайн объектыг дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбохын тулд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн харьяа дулаан дамжуулах төвийн хүчин чадал, дулаан дамжуулах, түгээх сүлжээг зайлшгүй өргөтгөхтэй холбогдон гарах зардлыг объектоо холбуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцна.

5.4 Тухайн объект нь техникийн нөхцөлийн дагуу хэрэглэгчийн өмчлөлийн дулааны шугам сүлжээ, дулаан дамжуулах төв, тоног төхөөрөмжөөс холбогдох нөхцөлд тухайн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв, тоног төхөөрөмжийг угсралттай холбогдон гарсан анхны хөрөнгө оруулалтын зардлыг тухайн хэрэглэгчийн шугамын урт болон дулааны ачааллын эзлэх хувиар тооцон ногдуулж болно.

5.5 Шинээр объект холбуулж буй иргэн, хуулийн этгээд нь бусдын өмчлөлийн дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж хүчин чадал, шугам сүлжээг өргөтгөх, нэмэгдүүлэх, холболтын схемийг өөрчлөх тохиолдолд гарах зардлыг хариуцна.

5.6 Барилга угсралтын ажил дууссан боловч объект бүрэн ашиглалтад орох хүртэл түр холболтоор дулаан хэрэглэх тохиолдолд уг хугацаанд хэрэглэсэн дулааны үнийг иргэн, хуулийн этгээд техникийн нөхцөл олгогчид төлсөн байна. Түр дулаан авч байгаа хэрэглэгч нь бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлийн дулааны сүлжээ, дулаан дамжуулах төвөөс холбогдсон бол техникийн нөхцөл олгогч нь уг хэрэглэгчийн төлбөрийг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дулааны төлбөрөөс хасаж тооцно.

5.7 Иргэн хуулийн этгээд нь газар доорх инженерийн шугам сүлжээг дайран гарах болон зам талбай, бут сөөг, зүлэг мод эвдэх, тайрах, тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг дулааны шугам барих зураг төсөлд тусгуулж, гүйцэтгүүлсэн байна.

5.8 Дулааны эрчим хүч хэрэглэгч нь олгосон техникийн нөхцөлийн дагуу өөрийн эзэмшлийн дулааны шугам тоноглолоос шинээр хэрэглэгч холбуулах үүрэгтэй бөгөөд өөрийн шугамаас хэрэглэгч холбох үйл ажиллагаанаас ашиг олох зорилгоор бизнес үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.9 Шинээр объект холбуулж буй иргэн, хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлийн дулаан дамжуулах төвийн хүчин чадал, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөсөн бол өргөтгөсөн тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлд үлдэнэ. Харин хэрэглэгчийн өмчлөлийн дулааны шугам сүлжээ, дулаан дамжуулах төв, тоног төхөөрөмжийг өргөтгөсөн бол хамтран байгуулсан гэрээний дагуу дулааны ачаалал, хөрөнгө оруулалтын хэмжээгээр өмчилнэ.

5.10 Иргэн, хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн шугам тоног төхөөрөмжид хэрэглэгч шинээр холбуулахдаа түгээх сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагаас тавих шаардлагыг биелүүлнэ.

Зургаа. Техникийн нөхцөл олгохгүй байх, хүчингүй болгох

6.1 Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр олгохгүй. Үүнд:

6.1.1 Газрын (өмчлөх, эзэмших) маргаантай болон газрын гэрчилгээ, кадастрын зураг, хүсэлт, бусад бичиг баримтын эзэмшигчийн нэр зөрсөн байх,

6.1.2 Техникийн нөхцөл авахад энэхүү журмын 2.3-т заасан материалыг дутуу бүрдүүлсэн бол хүлээн авах боломжгүй, мөн 2.4-т заасан

хүсэлтийн онцлогоос хамаарсан нэмэлт бичиг баримтыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрдүүлж өгөөгүй тохиолдолд,

6.1.3 Иргэн, хуулийн этгээдийн объектыг сүлжээнд холбоход тоноглолын нөөц хүрэлцэхгүй байх, шинээр барих, зөөх дэд станц, шугамын трасс нь тухайн орон нутгийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдахгүй, тухайн орчинд нийтийн сүлжээ үүсэх боломжийг хаах тохиолдолд,

6.2 Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

6.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон,

6.2.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд сүлжээнд холбогдоогүй.

Долоо. Хариуцлага

7.1 Иргэн, хуулийн этгээд нь өөрийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд болон санамсаргүй байдлаар буруу тодорхойлон техникийн нөхцөл батлагдсанаас гарсан хохирлыг өөрөө хариуцна.

7.2 Техникийн нөхцөлийг үндэслэл муутай эсвэл буруу боловсруулж олгосноос иргэн, хуулийн этгээдэд учирсан шууд хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

7.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг энэхүү журам болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

Холболтын журмын хавсралт

**ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН
НӨХЦӨЛ ОЛГОХ ТОДРУУЛАХ ХУУДАС**

Огноо

Дугаар

..... /хот, сум/

1. Техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага,
иргэний нэр хаяг, утас

2. Техникийн нөхцөл авах объектын байршил, хаягийн тодорхойлолт.

3. Техникийн нөхцөл авах болсон шалтгаан.

5. Хэрэглэгчийн зэрэглэл, ажлын горим

6. Цаашид өргөтгөх бол эхлэх, дуусах хугацаа, хүчин чадал (өргөтгөх бол хэзээ,
ямар хүчин чадал нэмэгдэх Гкал/ц)

7. Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын дугаар, огноо

8. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН (нэр)